

БАГШИД МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, ХАСАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1** Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага /цаашид сургалтын байгууллага гэх/-ын багш, сургалтын арга зүйч, сургалтын албаны менежер, бүсийн арга зүйн төвийн арга зүйч, менежер /цаашид багш гэх/-т багшийн мэргэжлийн зэрэг олгох, хасах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2** Энэхүү журмын зорилго нь багшийн мэргэжил, ур чадварын өсөлтийг тодорхойлж, сургалтын чанарыг үнэлж, санаачлагатай, бүтээлчээр ажиллаж үр дүнд хүрсэн амжилтыг баталгаажуулан багшийг дэмжин хөгжүүлэхэд оршино.
- 1.3** Мэргэжлийн зэрэг олгох, хасах гэдэгт сургалтын байгууллагад ажиллаж байгаа багшид зэрэг шинээр олгох, сунгах, ахиулах, хасах үйл ажиллагааг ойлгоно.
- 1.4** Багшид мэргэжлийн зэрэг олгох, шийдвэр гаргахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:
 - Үнэн бодитой байх
 - Шударга байх
 - Харилцан итгэлцэх
 - Хамтын оролцоонд суурилах
 - Ил тод байх
- 1.5** Багшид “Заах аргач багш”, “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” гэсэн мэргэжлийн зэрэг олгоно.
- 1.6** “Заах аргач багш” нь мэргэжлийн зэрэгтэй багшид тавигдах нийтлэг болон “Заах аргач багш”-д тавигдах ерөнхий, тусгай шалгуур, үзүүлэлтийг тус тус хангасан, сургалтын байгууллагын багш нарт зөвлөн хамтран ажиллах чадвартай байна.
- 1.7** “Тэргүүлэх багш” нь мэргэжлийн зэрэгтэй багшид тавигдах нийтлэг болон “Тэргүүлэх багш”-д тавигдах ерөнхий, тусгай шалгуур, үзүүлэлтийг тус тус хангасан, бүс, орон нутгийн багш нарт зөвлөх, багшийн хөгжилд хувь нэмэр оруулах чадвартай байна.
- 1.8** “Зөвлөх багш” нь мэргэжлийн зэрэгтэй багшид тавигдах нийтлэг болон “Зөвлөх багш”-д тавигдах ерөнхий, тусгай шалгуур, үзүүлэлтийг тус тус хангасан, үндэсний түвшинд багш нарт зөвлөн, салбарын хөгжилд хувь нэмэр оруулах чадвартай байна.
- 1.9** “Заах аргач багш” зэргийг сургалтын байгууллага, “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” зэргийг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус олгоно.
- 1.10** Багшид мэргэжлийн зэргийг шатлал алгасаж олгохгүй.

ХОЁР. МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ

- 2.1** Багшид мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагаа нь:
- Хүсэлт гаргах
 - Дүгнэлт гаргах
 - Шийдвэр гаргах гэсэн үе шаттайгаар явагдана.
- 2.2** Мэргэжлийн зэргийн шалгуур үзүүлэлтийн 80 түүнээс дээш оноо авсан тохиолдолд багшийг мэргэжлийн зэргийн шалгуур үзүүлэлтийг хангасанд тооцно.
- 2.3** Багш нь өөрийн ажлаа энэхүү журмын хоёрдугаар хавсралтад заасан шалгуур үзүүлэлт бүрээр үнэлж, нотлох баримтыг дугаарлан хавсаргаж, гуравдугаар хавсралтад заасан баримт бичгийг бүрдүүлэн, мэргэжлийн зэрэг хүссэн хүсэлтийн хамт жил бүрийн 06 дугаар сарын 01-ний дотор багтаан сургалтын байгууллагад хүргүүлнэ.
- 2.4** Мэргэжлийн зэргээ сунгуулах, ахиулах хүсэлтийг мэргэжлийн зэрэг хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнөх оны 06 дугаар сарын 01-ний дотор багтаан энэ журмын 2.3-д заасны дагуу сургалтын байгууллагад гаргана.
- 2.5** Багшид мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааг сургалтын байгууллага дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:
- 2.5.1** Сургалтын байгууллага зэрэг олгох ажлын хэсэг байгуулж, тухайн жилд мэргэжлийн “Заах аргач багш”, “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” зэрэг олгохыг хүссэн багшид үнэлгээ өгнө.
- 2.5.2** Сургалтын байгууллагын захирал нь ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн багшид “Заах аргач багш” мэргэжлийн зэрэг олгоно.
- 2.5.3** Сургалтын байгууллагын захирал нь “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг олгох хүсэлтийг жил бүрийн 06 сарын 05-ны дотор бүсийн арга зүйн төвд хүргүүлнэ.
- 2.6** Багшид мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааг бүсийн арга зүйн төв дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:
- 2.6.1** Бүсийн арга зүйн төв нь “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг хүссэн багшийн материалд үнэлгээ өгч, шалгуур үзүүлэлтийг хангасан багш нараас ерөнхий мэдлэгийн шалгалт авна.
- 2.6.2** Шалгуур үзүүлэлтийг хангасан багшийн материалыг жил бүрийн 06 дүгээр сарын 10-ний дотор Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
- 2.6.3** Мэргэжлийн зэрэгтэй багш нарын мэдээллийн санг бүрдүүлнэ.
- 2.7** Багшид мэргэжлийн зэрэг олгох үйл ажиллагааг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах байдлаар зохион байгуулна. Үүнд:
- 2.7.1** Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь шалгуур үзүүлэлтийг хангасан багшид “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” мэргэжлийн зэргийг жил бүрийн 06 дугаар сарын 25 -нд багтаан олгоно.
- 2.7.2** Мэргэжлийн зэргээ ахиулсан багш нар үнэмлэх хэвлүүлэхтэй холбогдон гарах зардлыг холбогдох Үндэсний үнэт цаас ХХК-ийн

дансанд тушааж баримтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

2.7.3 Багшийн мэргэжлийн зэргийн үнэмлэхийг мэргэжлийн зэрэг ахиулсан багш нарт хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд хүргэх ажлыг зохион байгуулна.

ГУРАВ. МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН НЭМЭГДЭЛ

- 3.1** “Заах аргач багш”, “Тэргүүлэх багш”, “Зөвлөх багш” зэрэгтэй багшид мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгоно.
- 3.2** Багшид мэргэжлийн зэргийн нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжид заагдсан хувь хэмжээгээр үндсэн цалингаас тооцож, эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн дараа оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн олгоно.
- 3.3** Сургалтын байгууллага нь мэргэжлийн зэрэгтэй багшийн тооны өөрчлөлтөд үндэслэн мэргэжлийн зэргийн нэмэгдэл хөлсөд шаардагдах зардлыг тооцож, жил бүр улсын төсөвт тусгуулж батлуулна.
- 3.4** Мэргэжлийн зэрэгтэй багшийн албан тушаал өөрчлөгдөж сургалтын байгууллагын захирал, эрхлэгчээр томилогдсон тохиолдолд тухайн мэргэжлийн зэрэг хүчинтэй байх хугацааг дуустал зэргийн нэмэгдлийг нь тухайн албан тушаалын үндсэн цалингаас тооцож олгоно.

ДӨРӨВ. БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ХҮЧИНТЭЙ БАЙХ ХУГАЦАА, БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙГ ХАСАХ

- 4.1** Багшид мэргэжлийн зэрэг олгосноос хойш “Заах аргач багш” 3 жил, “Тэргүүлэх багш” 5 жил, “Зөвлөх багш” 8 жилийн хугацаанд тус тус хүчинтэй байна.
- 4.2** Мэргэжлийн зэргээ хамгаалахад мэргэжлийн зэрэгт тавигдах нийтлэг, ерөнхий, тусгай шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд мэргэжлийн зэрэг олгох эрх бүхий байгууллага дүгнэлт гарган шийдвэрлэнэ.
- 4.3** Эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон дараах тохиолдолд мэргэжлийн зэрэг олгосон байгууллага багшийн мэргэжлийн зэргийг хасна. Үүнд:
 - 4.3.1** Энэхүү журмын 1.1-д зааснаас өөр албан тушаалд ажиллаж байгаа тохиолдолд
 - 4.3.2** Мэргэжлийн алдаа гаргасан
 - 4.3.3** Багш ёс зүйн дүрмийг зөрчсөн
 - 4.3.4** Суралцагчийн эрхэд халдсан
 - 4.3.5** Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэсэн, хэрэглэж ирсэн
 - 4.3.6** Авилга авсан
 - 4.3.7** Мэргэжлийн боловсролын байгууллагад гурав болон түүнээс дээш жил ажиллаагүй багшийн мэргэжлийн зэрэг хүчингүй болсонд тооцно.
- 4.4** Мэргэжлийн зэрэг нь хүчингүй болсон багш зэргээ сэргээх хүсэлтийг 1 жилийн дараа гаргаж болно.

- 4.5 Олон улсын болон үндэсний хэмжээний уралдаан тэмцээнд онцгой амжилт гаргасан, оюуны өмчийн бүртгэлийн гэрчилгээтэй бүтээл гаргасан тохиолдолд шалгуур үзүүлэлт болон хугацаа харгалзахгүй зэрэг олгож болно.
- 4.6 Багшийн мэргэжлийн зэрэг нь Монгол улсын нутаг дэвсгэрт нэгэн адил хүчинтэй байна.
- 4.7 Магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр хүндээр өвчилсөн, жирэмсэний амралт болон хүүхдээ асарч байгаа, 3-аас дээш сарын хугацаагаар гадаадад томилолтоор ажилласны улмаас мэргэжлийн зэрэг авах хүсэлт болон шаардлагатай материалаа журамд заасан хугацаанд өгч чадаагүй багшийн мэргэжлийн зэргийг нэг жилийн хугацаанд хүчин төгөлдөрт тооцож болно.
- 4.8 Энэхүү журмын 4.7-д заасан нөхцлөөс бусад тохиолдолд мэргэжлийн зэрэг сунгуулах, хугацаа хэтэрсэн болон мэргэжлийн зэрэг ахиулахаар хүсэлт гаргаж, зэрэг олгоход тавигдах шалгуур үзүүлэлтийг хангаагүй бол багшийн мэргэжлийн зэргийг хүчингүй болсонд тооцно.
- 4.9 Багш нь мэргэжлийн зэрэг олгоход бүрдүүлэх материалыг хуурамчаар бүрдүүлсэн, бусдын бүтээлийг ашигласан нь тогтоогдвол зэргийг хүчингүй болгоно.

ТАВ. БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН ҮНЭМЛЭХНИЙ ЗАГВАР

- 5.1 Багшид "Заах аргач багш", "Тэргүүлэх багш", "Зөвлөх багш" мэргэжлийн зэргийг гэрчлэх үнэмлэх олгоно.
- 5.2 Багшийн мэргэжлийн зэргийн үнэмлэхийг ижил хэмжээ, дизайн бүхий загвараар хийнэ. Үнэмлэхийн бичвэр, гадна буюу дотор өнгө нь мэргэжлийн зэрэг бүрээр ялгаатай байна. "Заах аргач багш" мэргэжлийн зэргийн үнэмлэх ногоон, "Тэргүүлэх багш" мэргэжлийн зэргийн үнэмлэх цэнхэр, "Зөвлөх багш" мэргэжлийн зэргийн үнэмлэх улаан өнгөтэй байна.
- 5.3 Зэргийн үнэмлэхний нүүрэн талд "Соёмбо" тэмдэг зурж, БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН ҮНЭМЛЭХ гэж алтан боронзоор үндэсний монгол бичгээр бичнэ.
- 5.4 Зэргийн үнэмлэхний дотор талын бичвэрийг дөрөвдүгээр хавсралтаар жишээ болгов.

ЗУРГАА. БУСАД

- 6.1 Багшийн мэргэжлийн зэргийн үнэмлэхийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу нөхөн олгоно.
- 6.2 Багшийн мэргэжлийн зэргийн үнэмлэхийг хуурамчаар үйлдэн ашиглахыг хориглоно.
- 6.3 Багшид мэргэжлийн зэрэгтэй холбоотой гарсан гомдлыг холбогдох дээд шатны байгууллагад гаргана.

Мэргэжлийн зэргийн шалгуур үзүүлэлтүүд

Мэргэжлийн зэрэг / шалгуур		Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш		
1. Нийтлэг шалгуур		<ul style="list-style-type: none"> • Багшлах эрхтэй байх • Багшийн ёс зүйн дүрмийг чанд сахидаг байх • МБС-ын сургах зүйн онцлогийг сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, үнэлж сайжруулах арга зүйг эзэмшсэн байх • Сургалтын чанар, үр дүнг сайжруулах бүтээлч арга зүй, технологи эзэмшсэн, шинэ санаачлага гаргасан байх • Өөрийгөө хөгжүүлэх хувийн хөгжлийн төлөвлөгөө гарган, тодорхой үр дүнд хүрсэн байх 		
Шалгуур үзүүлэлт		Заах аргач багш	Тэргүүлэх багш	Зөвлөх багш
2. Ерөнхий шалгуур	Сургалтын үр дүн	Хөндлөнгийн шалгалтаар сургалтын чанар тухайн жилд 10-аас доошгүй хувийн ахицтай байх	Хөндлөнгийн шалгалтаар сургалтын чанар тухайн жилд 10-аас доошгүй хувийн ахицтай байх	Хөндлөнгийн шалгалтаар сургалтын чанар тухайн жилд 10-аас доошгүй хувийн ахицтай байх
	Сургалтын арга зүй	Сургалт, арга зүйн туршлагаа хуваалцах, түгээн дэлгэрүүлэх ажлыг сургалтын байгууллагын түвшинд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнд хүрсэн байх	Сургалт, арга зүйн туршлагаа хуваалцах сургалт, түгээн дэлгэрүүлэх ажлыг бүс орон нутгийн хэмжээнд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнд хүрсэн байх	Сургалт, арга зүйн туршлагаа хуваалцах, түгээн дэлгэрүүлэх ажлыг үндэсний хэмжээнд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнд хүрсэн
		Заах арга зүйн уралдаанд сургалтын байгууллагын хэмжээнд амжилттай оролцсон	Заах арга зүйн уралдаанд бүс, орон нутгийн хэмжээнд амжилттай оролцсон	Заах арга зүйн уралдаанд Үндэсний хэмжээнд амжилттай оролцсон
	Сургалтын бичиг баримт боловсруулалт	Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, сэдвийн боловсруулалт /ажлын хуудас/ -ыг бүтээлчээр хэрэгжүүлсэн	Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, сэдвийн боловсруулалт /ажлын хуудас/ -ыг боловсруулж, хэрэгжүүлсэн	Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, сэдвийн боловсруулалт /ажлын хуудас/ -ыг боловсруулж, бүтээлчээр хэрэгжүүлэн, түгээн дэлгэрүүлсэн

	Судалгаа, шинжилгээний ажил	Сургалтын байгууллагын багш, суралцагчдын судалгаа, эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд амжилттай оролцсон	Бүс, орон нутгийн багш, суралцагчдын судалгаа, эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд амжилттай оролцсон	Үндэсний хэмжээнд багш, суралцагчдын судалгаа, эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд амжилттай оролцсон
	Мэргэжлийн уралдаан тэмцээн, олимпиад	Сургалтын байгууллагын мэргэж-лийн ур чадварын уралдаан, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд өөрөө болон шавь нар нь амжилттай оролцсон	Бүс, орон нутгийн ажил мэргэжлийн ур чадварын уралдаан, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд өөрөө болон шавь нар нь амжилттай оролцсон	Үндэсний ажил мэргэжлийн ур чадварын уралдаан, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд өөрөө болон шавь нар нь амжилттай оролцсон
	Өөрийгөө хөгжүүлэх	Боловсрол судлал, мэргэжил, сургалт арга зүйн чиглэлээр 3-аас доошгүй удаа сургалтад хамрагдаж, мэргэжил, ур чадвараа дээшлүүлсэн байх	Боловсрол судлал, мэргэжил, сургалт арга зүйн чиглэлээр 3-аас доошгүй удаа сургалтад хамрагдаж, мэргэжил, ур чадвараа дээшлүүлж, хэрэгжүүлсэн байх	Боловсрол судлал, мэргэжил, сургалт арга зүйн чиглэлээр 3-аас доошгүй удаа сургалтад хамрагдаж, мэргэжил, ур чадвараа дээшлүүлэн хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлсэн байх
3. Тусгай шалгуур		Сургуулийнхаа багш нарт зөвлөх, тэдэнтэй хамтран ажиллах чадвартай, сургуулийн хэмжээнд тэргүүлэгч багш байх	Ажил мэргэжлээрээ тэргүүлэх чадвартай, туршлага нь бүс, орон нутгийн хэмжээнд сурталчлагдсан байх	Зөвлөн туслах үйл ажиллагааг тогтмол явуулдаг, туршлага нь бүс, үндэсний хэмжээнд сурталчлагдсан байх
		Сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлага /8х/х-аас доошгүй/ боловсруулсан байх	Багш, суралцагчдад зориулсан гарын авлага /8х/х-аас доошгүй/, зөвлөмж, сурах бичиг боловсруулсан байх	Багш, суралцагчдад зориулсан гарын авлага, зөвлөмж боловсруулан, сургалтадаа хэрэглэдэг байх 2-оос доошгүй мэргэжлийн сурах бичиг боловсруулсан байх
		Цахим хичээл боловсруулах арга зүйд суралцсан байх	Цахим хичээл боловсруулах арга зүйд суралцан хичээл боловсруулж сургалтад ашигласан байх	Цахим хичээл боловсруулж туршлагаа түгээн дэлгэрүүлж, зөвлөн тусласан байх

Мэргэжлийн зэргийн шалгуур үзүүлэлтийн оноо /Багш/

2. Ерөнхий шалгуур	Мэргэжлийн зэрэг / шалгуур		Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш					
	1. Нийтлэг шалгуур		<ul style="list-style-type: none"> • Багшлах эрхтэй байх • Багшийн ёс зүйн дүрмийг чанд сахидаг байх • МБС-ын сургах зүйн онцлогийг сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, үнэлж сайжруулах арга зүйг эзэмшсэн байх • Сургалтын чанар, үр дүнг сайжруулах бүтээлч арга зүй, технологи эзэмшсэн, шинэ санаачлага гаргасан байх • Өөрийгөө хөгжүүлэх хувийн хөгжлийн төлөвлөгөө гарган, тодорхой үр дүнд хүрсэн байх 					
	Шалгуур үзүүлэлт		Заах аргач		Тэргүүлэх		Зөвлөх	
	Сургалтын үр дүн	*20	Хөндлөнгийн шалгалтаар сургалтын чанар тухайн жилд 10-аас доошгүй хувийн ахицтай байх	20	Хөндлөнгийн шалгалтаар сургалтын чанар тухайн жилд 10-аас доошгүй хувийн ахицтай байх	20	Хөндлөнгийн шалгалтаар сургалтын чанар тухайн жилд 10-аас доошгүй хувийн ахицтай байх	20
	Сургалтын арга зүй	0-15	Сургалт, арга зүйн туршлагаа хуваалцах, түгээн дэлгэрүүлэх ажлыг сургалтын байгууллагын түвшинд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнд хүрсэн байх	0-10	Сургалт, арга зүйн туршлагаа хуваалцах сургалт, түгээн дэлгэрүүлэх ажлыг бүс орон нутгийн хэмжээнд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнд хүрсэн байх	0-10	Сургалт, арга зүйн туршлагаа хуваалцах, түгээн дэлгэрүүлэх ажлыг үндэсний хэмжээнд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнд хүрсэн	0-10
			Заах арга зүйн уралдаанд сургалтын байгууллагын хэмжээнд амжилттай оролцсон	0-5	Заах арга зүйн уралдаанд бүс, орон нутгийн хэмжээнд амжилттай оролцсон	0-5	Заах арга зүйн уралдаанд Үндэсний хэмжээнд амжилттай оролцсон	0-5

Сургалтын бичиг баримт боловсруулалт	0-15	Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, сэдвийн боловсруулалт /ажлын хуудас/ -ыг бүтээлчээр хэрэгжүүлсэн	0-15	Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, сэдвийн боловсруулалт /ажлын хуудас/ -ыг боловсруулж, хэрэгжүүлсэн	0-15	Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, сэдвийн боловсруулалт /ажлын хуудас/ -ыг боловсруулж, бүтээлчээр хэрэгжүүлэн, түгээн дэлгэрүүлсэн	0-15
Судалгаа, шинжилгээний ажил	0-10	Сургалтын байгууллагын багш, суралцагчдын судалгаа, эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд амжилттай оролцсон	0-10	Бүс, орон нутгийн багш, суралцагчдын судалгаа, эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд амжилттай оролцсон	0-10	Үндэсний хэмжээнд багш, суралцагчдын судалгаа, эрдэм шинжилгээ, онол практикийн хуралд амжилттай оролцсон	0-15
Мэргэжлийн уралдаан тэмцээн, олимпиад	0-5	Сургалтын байгууллагын мэргэжлийн ур чадварын уралдаан, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд өөрөө болон шавь нар нь амжилттай оролцсон байх	0-5	Бүс, орон нутгийн ажил мэргэжлийн ур чадварын уралдаан, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд өөрөө болон шавь нар нь амжилттай оролцсон байх	0-5	Үндэсний ажил мэргэжлийн ур чадварын уралдаан, олимпиад, бүтээлийн үзэсгэлэнд өөрөө болон шавь нар нь амжилттай оролцсон байх	0-5
Өөрийгөө хөгжүүлэх	0-5	Боловсрол судлал, мэргэжил, сургалт арга зүйн чиглэлээр 3-аас доошгүй удаа сургалтад хамрагдаж, мэргэжил, ур чадвараа дээшлүүлсэн байх	0-5	Боловсрол судлал, мэргэжил, сургалт арга зүйн чиглэлээр 3-аас доошгүй удаа сургалтад хамрагдаж, мэргэжил, ур чадвараа дээшлүүлж, хэрэгжүүлсэн байх	0-5	Боловсрол судлал, мэргэжил, сургалт арга зүйн чиглэлээр 3-аас доошгүй удаа сургалтад хамрагдаж, мэргэжил, ур чадвараа дээшлүүлэн хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлсэн байх	0-5
Нийт оноо	70		70		70		70

3. Тусгай шалгуур	Сургуулийнхаа багш нарт зөвлөх, тэдэнтэй хамтран ажиллах чадвартай, сургуулийн хэмжээнд тэргүүлэгч багш байх	0-10	Ажил мэргэжлээрээ тэргүүлэх чадвартай, туршлага нь бүс, орон нутгийн хэмжээнд сурталчлагдсан байх	0-10	Зөвлөн туслах үйл ажиллагааг тогтмол явуулдаг, туршлага нь бүс, үндэсний хэмжээнд сурталчлагдсан байх	0-10
	Сургалтын хэрэглэгдэхүүн, гарын авлага /8 хэвлэлийн хуудсаас доошгүй байх/ боловсруулсан байх	0-10	Багш, суралцагчдад зориулсан гарын авлага /8х/х-аас доошгүй/, зөвлөмж, сурах бичиг боловсруулсан /багт ажилласан/ байх	0-10	Багш, суралцагчдад зориулсан гарын авлага, зөвлөмж боловсруулан, сургалтадаа хэрэглэдэг байх 2-оос доошгүй мэргэжлийн сурах бичиг боловсруулсан /багт ажилласан/ байх	0-10
	Цахим хичээл боловсруулах арга зүйд суралцсан байх	0-10	Цахим хичээл боловсруулах арга зүйд суралцан хичээл боловсруулж сургалтад ашигласан байх	0-10	Цахим хичээл боловсруулж туршлагаа түгээн дэлгэрүүлж, зөвлөн тусалсан байх	0-10
Нийт оноо	30	30		30		30

Тусгай шалгуур үзүүлэлтийн оноо /Сургалтын менежер, арга зүйч, Бүсийн АЗТ-ийн менежер, арга зүйч/

2. Шалгуур үзүүлэлт	Үзүүлэлт		Шалгуур		
			Тэргүүлэх	Зөвлөх	
Суралцагчдын стандарт хангалт	30	Мэргэжлийн боловсрол сургалтын стандартын хэрэгжилтийг тогтоох хөндлөнгийн шалгалтаар сургуулийн суралцагчдын сурлагын дундаж амжилт нь тухайн зэрэг хүчинтэй байх хугацаанд өмнөх түвшингээс 15-аас дээш хувиар тогтмол өсөж, багш суралцагчдаа хөгжүүлэх, сургалтын чанарыг сайжруулахад /онцгойлон тэмдэглэх/ жилд 1-ээс доошгүй амжилт гаргасан			30

Сургалтын бичиг баримт боловсруулалт	40	Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, үнэлгээний баримт бичгүүд, сургалтын үйл ажиллагаанд шаардлагатай дүрэм, журам боловсруулах ажлыг удирдан зохион байгуулсан	Багш нараа хөгжүүлэх, мэргэжлийг нь дээшлүүлэх талаар бүтээлч туршлагаа үндэсний хэмжээнд 2-оос доошгүй удаа сурталчилан түгээн дэлгэрүүлсэн	20
		Бүс орон нутгийн хэмжээнд сургалтын менежмент, багшийн хөгжил, боловсролын стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн боловсруулалт зэрэг чиглэлээр 2-оос доошгүй сургалт зохион байгуулсан	Үндэсний хэмжээнд сургалтын менежмент, багшийн хөгжил, боловсролын стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн боловсруулалт зэрэг чиглэлээр 2-оос доошгүй сургалт зохион байгуулсан	20
Судалгаа, шинжилгээний ажил		Бүс орон нутгийн хэмжээнд эрдэм шинжилгээ, онол практикийн хурал, зөвлөгөөнд сургалтын менежмент, багш суралцагчийн хөгжил, нийгмийн түншлэл, боловсролын стандарт, чадамжид суурилсан сургалтын стандарт, хөтөлбөр боловсруулалт зэрэг асуудлаар судалгаа хийж, үр дүнгээр нь 2-оос доошгүй удаа илтгэл хэлэлцүүлсэн	Үндэсний хэмжээний эрдэм шинжилгээ, онол практикийн хурал, зөвлөгөөнд сургалтын менежмент, багшийн хөгжил, боловсролын стандарт, чадамжид суурилсан сургалтын стандарт, хөтөлбөр боловсруулалт зэрэг асуудлаар судалгаа хийж, үр дүнгээр нь 2-оос доошгүй удаа илтгэл хэлэлцүүлж, эмхэтгэлд хэвлүүлсэн	10
		Багш, суралцагчдад зориулсан ном, сурах бичиг, гарын авлага, зөвлөмж /8х.х-аас доошгүй/, мэргэжлийн стандарт, ажил мэргэжлийн лавлах, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулан сургалтын үйл ажиллагаанд ашигласан	Багш, суралцагчдад зориулсан ном, сурах бичиг, гарын авлага, зөвлөмж /8х.х-аас доошгүй/, мэргэжлийн стандарт, ажил мэргэжлийн лавлах, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулан сургалтын үйл ажиллагаанд ашиглан үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлсэн	10
		Бүс орон нутгийн хэмжээнд үйлдвэрлэлд нэвтэрч байгаа шинэ техник, технологийг судалж, сургалтад үр дүнтэй нэвтрүүлэх ажлыг амжилттай зохион байгуулсан, сайн туршлагын түгээн дэлгэрүүлсэн	үйлдвэрлэлд нэвтэрч байгаа шинэ техник, технологийг судалж, сургалтад үр дүнтэй нэвтрүүлэх ажлыг Үндэсний хэмжээнд зохион байгуулж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлсэн	10
Бусад		Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын хөгжлийг дэмжсэн үндэсний хэмжээний хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэхэд тодорхой үүрэг хүлээн тогтвортой ажилласан, мөн боловсрол судлал, мэргэжлийн боловсрол, сургалтын болон техникийн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан бол мэргэжлийн тухайн зэрэгт харгалзах үзүүлэлтийг холбогдох баримт бичгийг үндэслэн 50 хувь хангасанд тооцно.		
Нийт оноо	100			100

Мэргэжлийн зэрэг авахыг хүссэн багшийн бүрдүүлэх материал

Доор дурьдсан материалыг бүрдүүлж, хавсаргана.

- Мэргэжлийн зэрэг олгохыг хүссэн сургуулийн тодорхойлолт, албан тоот
- Мэргэжлийн зэрэг авахыг хүссэн багшийн хувийн мэдээлэл

САНАМЖ: Маягтыг өөрийн гараар, хар буюу хөх өнгийн бэхээр бөглөнө. Сонгох хариултыг “ ✓ ” тэмдэгээр тэмдэглэнэ.

ХУВЬ ХҮНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ:

1. Овог _____ Нэр _____

2. Хүйс /эрэгтэй, эмэгтэй/ _____

3. Төрсөн _____ он _____ сар

4. Ажиллаж буй сургалтын байгууллага

Зураг

5. Албан тушаалын нэр

- Багш Сургалтын арга зүйч Сургалтын албаны менежер
 Бүсийн арга зүйн төвийн менежер Бүсийн арга зүйн төвийн арга зүйч

6. Заадаг хичээл _____

7. Мэргэжлийн зэргийн талаарх мэдээллийг тохирох нүдэнд сонгож, тэмдэглэнэ.

Хүчин төгөлдөр байгаа мэргэжлийн зэрэг	Мэргэжлийн зэргийн хүсэлт	Авахыг хүссэн мэргэжлийн зэрэг
<input type="checkbox"/> Заах аргач багш	<input type="checkbox"/> Шинээр авах	<input type="checkbox"/> Заах аргач багш
<input type="checkbox"/> Тэргүүлэх	<input type="checkbox"/> Сунгуулах	<input type="checkbox"/> Тэргүүлэх
<input type="checkbox"/> Зөвлөх	<input type="checkbox"/> Зэрэг ахиулах	<input type="checkbox"/> Зөвлөх

8. Боловсролын талаарх мэдээлэл

Боловсрол /Ерөнхий, тусгай дунд, дээд боловсрол, дипломын, бакалаврын болон магистрын зэргийг оролцуулна/

Сургуулийн нэр	Орсон он, сар	Төгссөн он, сар	Эзэмшсэн боловсрол, мэргэжил, гэрчилгээ, дипломын дугаар

9. Боловсролын докторын болон шинжлэх ухааны докторын зэрэг

Зэрэг	Хамгаалсан газар	Он, сар	Гэрчилгээ, дипломын дугаар

10. Мэргэшлийн бэлтгэл /Мэргэжлийн болон бусад чиглэлээр өмнөх зэрэг авснаас хойш нарийн мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байдлыг бичнэ/

Хаана, ямар байгууллагад	Эхэлсэн, дууссан он, сар, өдөр	Хугацаа /хоногоор/	Ямар чиглэлээр	Үнэмлэх, гэрчилгээний дугаар, олгосон он, сар, өдөр

11. Гадаад хэлний мэдлэг / Дохионы хэлийг оролцуулан тооцно /

Гадаад хэлний нэр	Сонсож ойлгох			Ярих			Унших			Бичих		
	Дунд	Сайн	Онц	Дунд	Сайн	Онц	Дунд	Сайн	Онц	Дунд	Сайн	Онц

12. Хөдөлмөр эрхлэлтийн байдал

Ажилласан байгууллага, газар, түүний хэлтэс, алба	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр

Мэдээллийг оны сарын - ны өдөр бөглөв.

Гарын үсэг

Мэдээллийг сургуулийн захирал нь бүрэн зөв бөглөсөн эсэхийг шалгаад гарын үсгээ зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулна.

Сургуулийн захирал/..... /

Үнэмлэхний дугаар

Бүртгэлийн дугаар МБ-3-.....



Овог: _____

Нэр: _____

захирлын 20...оны ...-р сарын ...-ны өдрийн
тушаалыг үндэслэн “ЗААХ АРГАЧ БАГШ”
мэргэжлийн зэргийн үнэмлэх олгов.

Захирал: _____
/тэмдэг, гарын үсэг/

Олгосон: 20 ...оны ...-р сарын ...-ны өдөр

Бүртгэлийн дугаар МБ-3-.....

Сунгалт

захирлын 20...оны ...-р сарын ...-ны өдрийн
тушаалыг үндэслэн
20 ...оны ...-р сарын ...-ны өдөр хүртэл сунгав.

Захирал: _____
/тэмдэг, гарын үсэг/

Бүртгэлийн дугаар МБ-3-.....

Сунгалт

захирлын 20...оны ...-р сарын ...-ны өдрийн
тушаалыг үндэслэн
20 ...оны ...-р сарын ...-ны өдөр хүртэл сунгав.

Захирал: _____
/тэмдэг, гарын үсэг/

Үнэмлэхний дугаар

Бүртгэлийн дугаар МБ-2-



зураг

Овог: _____

Нэр: _____

“Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш
нарт мэргэжлийн зэрэг олгох тухай”

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 20... оны ...-р сарын ...-ны өдрийн
тушаалыг үндэслэн “ТЭРГҮҮЛЭХ БАГШ”
мэргэжлийн зэргийн үнэмлэх олгов.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

МБСБХЗГ-ын дарга: _____

/тэмдэг, гарын үсэг/

Олгосон: 20 ...оны ...-р сарын ...-ны өдөр

Бүртгэлийн дугаар МБ-2-

Сунгалт

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 20... оны ...-р сарын ...-ны өдрийн
....тушаалыг үндэслэн
20 ...оны ...-р сарын ...-ны өдөр хүртэл сунгав.

МБСБХЗГ-ын дарга: _____

/тэмдэг, гарын үсэг/

Үнэмлэхний дугаар

Бүртгэлийн дугаар МБ-1-.....



зураг

Овог: _____

Нэр: _____

“Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш нарт мэргэжлийн зэрэг олгох тухай”

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 20... оны ...-р сарын ...-ны өдрийн тушаалыг үндэслэн **“ЗӨВЛӨХ БАГШ”** мэргэжлийн зэргийн үнэмлэх олгов.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

МБСБХЗГ-ын дарга: _____

/тэмдэг, гарын үсэг/

Олгосон: 20 ...оны ...-р сарын ...-ны өдөр

Бүртгэлийн дугаар МБ-1-.....

Сунгалт

Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 20... оны ...-р сарын ...-ны өдрийнтушаалыг үндэслэн 20 ...оны ...-р сарын ...-ны өдөр хүртэл сунгав.

МБСБХЗГ-ын дарга: _____

/тэмдэг, гарын үсэг/